

БЭЭЖИН ХОТЫН ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

Ч.Таамаа*

БНХАУ-ын нийслэл Бээжин хот нь 3 мянга гаруй жилийн түүхтэй эртний хот. Бээжин хотыг Хятадын Жоу улсын¹ үед “Зичэн” хэмээн нэрлэн, гар урлал, худалдаа арилжаа нэлээд хөгжсөн төв байв. Хятан гүрний үед Бээжин хотыг Яньжин хэмээн нэрлэж байсан бөгөөд тус гүрний өмнөд нийслэл байжээ.² 940 онд Хятан гүрний эзэн хаан Елюй Дэгуан энэхүү өмнөд нийслэлд ирж ёслол үйлдэж байсан тухай түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг.³ 1036 оноос Хятан гүрний хаад Яньжин хотод орд харш, гоёмсог барилга байгууламжийг олноор барьж, хотын хэмжээг нэлээд өргөтгөжээ.⁴ Тухайн үед Яньжингийн хүн ам 300 мянга гаруй байсан нь⁵ хүн амын хувьд авч үзвэл нэлээд том хот суурин газар байжээ. Хятан гүрэнд бурханы шашин нэлээд дэлгэрч байсан учир том жижиг олон сүм хийдийг гол гол газартаа байгуулж байлаа. Тухайлбал, Яньжин хотын ойролцоо байгуулсан “Таньжэ сы” хэмээх нэртэй нүсэр том хийд /2,5 гектар талбайг эзэлсэн/ эдүгээ музей болон ажиллаж байна.⁶

Алтан улсын үед Бээжин хотыг Жунду хэмээн нэрлэж тус улсын нийслэл байв. Яньжин хотыг анх 1153 онд Жунду хэмээн нэрлэх болжээ.⁷ Алтан улсын Ванянь Лянь хаан 1151 онд Алтан улсын нийслэлийг Яньжинд байгуулахаар шийдвэрлэн зарлиг буулгасан бөгөөд 1153 онд зохих бэлтгэл ажлыг хийсний дараа 1153 онд Яньжин хотыг Жунду хэмээн нэрлэж нийслэл болгосноо албан ёсоор зарлажээ.⁸ Жунду хот Алтан улсын нийслэл болсноос хойш нэлээд өргөжиж, хотын эргэн тойрны

хэмжээг 35-37 ли /ли- уртын нэгж бөгөөд 0,5 км-тэй тэнцэнэ/ хүрчээ.⁹ Алтан улсын ноёрхогчид Жунду хотын хүн амын хоол хүнс, эд барааны хэрэгцээг хангах зорилгоор тээвэр харилцааг хөгжүүлэх талаар нэлээд анхаарал тавьж ялангуяа гол мөрөн дээр олон гүүр бариулжээ. Тухайлбал, 1189 онд Жунду хотыг Шаньдун, Хэбэй, Хэнань зэрэг мужуудтай холбосон Лугоучяо хэмээх нэртэй чулуун гүүр босгожээ. Энэхүү гүүрийг 1192 онд ашиглалтанд оруулснаас хойш эдүгээ хүртэл 812 жил ашигласаар байна. Лугоучяо гүүрний урт нь 260,5 метр, өргөн нь 7,5 метр бөгөөд умард Хятадын хамгийн том чулуун гүүр байжээ.¹⁰

Алтан улсын нийслэл Жунду хотыг Эзэн богд Чингис хааны цэрэг 1215 онд эзэлж, хотын хуучин нэрийг сэргээн Яньжин хэмээн нэрлэж байсан.¹¹ 1273 онд Яньжин хот Монголын Юан улсын нийслэл болж, Дайду хэмээн нэрлэгдэх болжээ.¹² 1293 оны байдлаар Дайду хот 100 мянган хүн амтай байсан тухай сурвалж бичигт тэмдэглэжээ.¹³ Хятан гүрний үед Яньжин, Алтан улсын үед Жунду, Монголын Юан улсын үед Дайду хэмээн тус тус нэрлэж байсан энэхүү хотыг 1421 оноос Бээжин гэж нэрлэх болжээ. Харин 1368-1421, 1928-1949 онуудад Бэйпин гэж нэрлэж байлаа.¹⁴

1949 оноос Бээжин хот БНХАУ-ын нийслэл болж, тус улсын улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухааны төв болжээ. Бээжин хот эдүгээ Дунчэн, Сэчиэн, Сюань-у, Чунвень, Чао-ян, Фэнтай, Хайдянь, Фаншан, Шизэн-шань, Мэньтоугоу, Тунжоу зэрэг 11 дүүрэг Хуэйжоу, Миёюнь, Чанпин,

* Ч.Таамаа. МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн багш, доктор (Sc.D), профессор

Яньцин, Пингу, Дасин, Шунь-и зэрэг 7 сяниас /сянь- засаг захиргааны нэгж/ бүрдэнэ. 16807 хавтгай дөрвөлжин км талбай бүхий Бээжин хотод машин механизм, металлурги, нүүрс, нефть боловсруулах, хими, нэхмэл, электрон, барилгын материал зэрэг аж үйлдвэрийн газрууд байхаас гадна хивс, архи, пиво, ундаа, чихэр, боовны олон үйлдвэр ажилладаг. Төмөр замаар Харбин, Гуанжоу, Шэньжэн, Тяньзин, Сямэн, Ниньбо, Далянь, Шанхай, Хөх хот, Бугат, Тайюань, Зюлун зэрэг Хятадын томоохон хотуудтай шууд холбоотой байхаас гадна Улаанбаатар, Москва, Ханой, Пхеньян зэрэг гадаад орны нийслэл хотуудтай холбоотой байна. Агаарын шугамаар дэлхийн 32 орны 62 хоттой шууд харилцаатай.¹⁵ Бээжин хот нь БНХАУ-ын шинжлэх ухаан, соёл боловсролын төв бөгөөд Хятад улсын Шинжлэх ухааны академи, Хятад улсын Нийгмийн шинжлэх ухааны академи, Бээжингийн их сургууль, Цинхуа их сургууль, Бээжингийн багшийн их сургууль, Хятад улсын ардын их сургууль зэрэг олон арван их дээд сургууль байдаг.¹⁶

Тайлбар, зүүлт:

1. Жоу улсыг дотор нь Баруун Жоу /МЭӨ XI-ҮШ зуун/, Зүүн Жоу /МЭӨ ҮШ-III зуун/ гэж хуваадаг.
2. Х.Пэрлээ. Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь, УБ, 1959, 44 дэх тал. Хятан гүрэнд тухайн үед дээд, дорнод, дундад, өмнөд, өрнөд гэсэн 5 нийслэлтэй байсан.
3. “Ляо улсын түүх”, 4-р дэвтэр.
4. “Ляо улсын түүх”, 18, 40-р дэвтэр.
5. “Хятан улсын ойллого” (Чидань гочжи), 22-р дэвтэр.
6. “Таньжэ сы” хэмээх хийд 1700 гаруй жилийн түүхтэй. Энэ хийдийн талаар Юань Шусиний бичсэн “Таньжэ сы” номыг үзнэ үү.

7. “Хятадын түүхийн их толь бичиг” (Жунго лиши да цыдянь), Шанхай, 1986, 71 дэх тал., “Алтан улсын түүх”, 8-р дэвтэр.
8. “Алтан улсын түүх”, 75, 79, 83-р дэвтэр.
9. Янь Вэнжу. “Зинь Жунду”, “Соёлын өв” (Вэнь-у), сэтгүүл, 1959, № 9.
10. “Үгсийн далай” (Цыхай), Бээжин, 2000, 216 дахь тал.
11. “Юан улсын судар”, 150, 153-р дэвтэр.
12. “Монгол улсын түүх”, дэд боть, УБ, 2003, 167, 292, 325 дахь тал. “Хятадын түүхийн их толь бичиг” (Чжунго лиши да цыдянь), Шанхай, 1986, 14 дэх тал.
13. “Их Юан улсын сан хөмрөгийн тэмдэглэл” (Даюань цанку цзи).
14. “Советский энциклопедический словарь”, Москва, 1985, стр. 976.
15. “Китай-2003”, Изд. “Синьсин”, Пекин, 2003, стр. 142.
16. “Дэлхийн нэвтэрхий толь” (Шицзе да байкэ), 1-р боть, Бээжин, 2004, 170 дахь тал.

Ашигласан ном зохиол:

1. “Юан улсын судар”, 150, 153-р дэвтэр.
2. “Алтан улсын түүх”, 8, 75, 79, 83-р дэвтэр.
3. “Ляо улсын түүх”, 4, 15, 18-р дэвтэр.
4. Х.Пэрлээ. Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь, УБ, 1959.
5. “Өнөөгийн Хятад орон”, УБ, 1996.
6. Ж.Баясах. Хятадын товч түүх, УБ, 2002.
7. “Монгол улсын түүх”, дэд боть, УБ, 2003.
8. “Советский энциклопедический словарь”, Москва, 1985.
9. “Дэлхийн нэвтэрхий толь” (Шизе да байкэ), 1-р боть, Бээжин, 2004
10. “Китай-2003”, Изд. “Синьсин”, Пекин, 2003.
11. “Үгсийн далай” (Цыхай), Бээжин, 2000.
12. Ван Шуньхун. Хятад улсын тойм (Жунго гайкуан), Бээжин, 1994.
13. Жан Жэнмин. Хятаны товч түүх (Чидань шилюе), Бээжин, 1979